



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 515

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.5, 6.6, 6.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Дорнод аймаг дахь Нисэх буудлын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 5,000,00.00 (таван сая) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Алтанцом, Дорнод аймаг дахь нисэх буудлын дарга Ц.Юрабаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, эргэлтийн хөрөнгөд орлогод авах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Акталж данснаас хассан тээврийн хэрэгслийг улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.Нарангэрэл

Д.НАРАНГЭРЭЛ

132001381

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2021 оны 11
дүгээр сарын 11-ний өдрийн 375
дугаар тогтоолын хавсралт

**"Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Дорнод аймаг дахь нисэх
буудлын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах хөрөнгийн
жагсаалт**

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын, Хуримтлагдсан элэгдэл дүн (төгрөг)
1	SF-220 маркийн жижиг трактор, 6631 УБ улсын дугаартай	2010-04-01	1	5,000,000.00	5,000,000.00
	ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН		1 (нэг)		5,000,000.00 (таван сая)